

“ЭМЧ” ХӨТӨЛБӨРИЙН 2021-2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2025.01.10

Эрдэнэт хот

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020 он	Хүрэх түвшин 2024 он	Хүрсэн түвшин 2024 он	Биелэлт	Хэрэгжилт /хувь/
Зорилт 1. Эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн ур чадвар, төлөвшил, ёс зүй, хандлагыг нэмэгдүүлэх							
1	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон магистр, докторын сургалтад төлөвлөлтийн дагуу хамруулах	Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	71.4	80%	86%	2021-2024 онд төрийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 500 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн суралцсан. ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төгсөлтийн дараах сургалтын “Ерөнхий мэргэшил судлал”-аар 2022-2024 онд 6 резидент эмч, “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 8, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 8 сувилагч тус тус төгссөн. Тус төслийн хүрээнд "Шинэ сувилагчийн сургалтын хөтөлбөр", "Эмнэл зүйн шатлал"-ийн хөтөлбөрийг улсын хэмжээнд анх удаа эхлүүлэн, хөтөлбөрийн хүрээнд 3 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, 12 шинэ сувилагчийг хөтөлбөрийн дагуу ажлын байранд нь дадлагажуулсан. Төрийн санхүүжилтээр 2021-2024 онд үндсэн мэргэшлээр суралцсан 12 эмч төгсөн ирж БОЭТ-д суралцсан чиглэлээр үргэлжлүүлэн ажиллаж байна. Тус хугацаанд давхардсан тоогоор 5702 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажлын байрны, алсын зайн сургалтад хамрагдсан нь нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 91%-ийг эзэлж байна. Үр дүн: Тайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн 14.6%-иар нэмэгдсэнээр төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 86%-д хүрсэн.	100
2	Орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэшүүлэх сургалтад хамрагдахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	70%	90%	92%	2021-2024 онд орон нутагт нэн шаардлагатай 23 мэргэшлээр 32 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургасан. Үүнд: -Компьютертомограф соронзон давтамж бүхий дүрс оношилгоо судлал, ангиограф судсан дотуурх эмчилгээ оношилгоо судлалаар 3 эмч, - Тархины судасны бичлэг судлалаар 1 эмч, - Хүүхдийн мэс засал судлалаар 1 эмч, - Хүүхдийн дүрс оношилгоо судлал 1, - Мэдрэлийн мэс засал судлал 2, - Түлэнхийн нөхөн сэргээх мэсэл засал судлал 1, - Чих, хамар хоолойн мэс засал судлал 1, - Элэг цөс хавдрын мэс засал судлал 1,	100

						- Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал судлал Үр дүн: Аймгийн хэмжээнд нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийн эзлэх хувь 92% болж өмнөх оноос 5 хувиар, суурь түвшнээс 22 хувиар нэмэгдсэн байна.	
3	Сургалт, эрдэм шинжилгээний ажлыг хийх боломжоор хангах, судалгаа шинжилгээний ажил хийх, өгүүлэл нийтлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Судалгаа, шинжилгээний ажлын тоо, үр дүн	1	4	180	Судалгааны арга зүйн чадавхжуулах сургалтыг АШУҮИС-тай хамтран зохион байгуулж нийт 68 эмч, сувилагчийг хамруулсан. Дэлхийн эмч нарын өдөр болон Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан тайлант хугацаанд 4 удаа Эрдэм шинжилгээний бага хурлыг орон нутгийн 8.4 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулж, 180 судалгаа шинжилгээний илтгэл хэлэлцүүлэгдсэн ба шалгарсан 65 илтгэлийг эмхэтгэн “Анагаах увидас” сэтгүүлд хэвлүүлснээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд гарын авлага болгон ашиглаж байна. Тус сэтгүүлийг хэвлүүлэхэд 12.0 сая төгрөгийг “Эмч” хөтөлбөрөөс санхүүжүүлсэн. Нотолгоонд суурилсан анагаах ухаан, эмнэлзүйн заавар ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор: - UpToDate программын хэрэглээг өргөжүүлэх зорилгоор 4 удаагийн сургалтад 80 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, анагаахын англи хэлийг сайжруулах анхан шатны сургалтад 10 эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. - “UpToDate программын хэрэглээг өргөжүүлэх нь” ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулж, эрүүл мэндийн салбарын 7 багийн 35 эмч оролцсоноос тэргүүн байрыг Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, дэд байрыг Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төв, гутгаар байрыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн баг тус тус эзэлж шагнагдсан. Үр дүн: Нийт эмч нарын 72.5% нь тус платформд бүртгэл үүсгэн ашиглаж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2.5 хувиар нэмэгдсэн байна. Судалгаа, шинжилгээний ажил 180 хийгдэж, мэдээллийн сан үүсгэгдэн, эмч эмнэлгийн мэргэжилтнүүд ашиглаж байна.	100
4		Судалгаа, шинжилгээний ажил хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	17%	20%	15.4%	Тайлант хугацаанд 160 судалгааны ажлыг 520 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамтран хийсэн бөгөөд олон улсын хэмжээнд 5 илтгэл, улсын хэмжээнд 11 илтгэл хэлэлцүүлэгдсэн байна. Тухайлбал: 2021 онд 86 эмнэлгийн мэргэжилтний 26, 2022 онд 104 эмнэлгийн мэргэжилтний 62, 2023 онд 224 эмнэлгийн мэргэжилтний 40, 2024 онд 106 эмнэлгийн мэргэжилтний 32 судалгаа шинжилгээний илтгэл тус тус хэлэлцүүлэгдсэн байна. Үр дүн: Судалгаа, шинжилгээний ажил хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 2021 онд 12%, 2022 онд 18%, 2023 онд 19.5%, 2024 онд нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 15.4 хувийг тус тус эзэлж байна.	77.0

5	Мэргэжлийн зэрэг ахиулахад дэмжлэг үзүүлэх	Мэргэжлийн зэрэгтэй эмчийн эзлэх хувь	22.1%	26%	29.5%	Тайлант хугацаанд тэргүүлэх зэргийг 53 мэргэжилтэн, ахлах зэргийг 76, зөвлөх зэргийг 10 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус хамгаалснаар аймгийн хэмжээнд нийт зөвлөх зэрэгтэй 19, тэргүүлэх зэрэгтэй 114, ахлах зэрэгтэй 193 эмч, эмнэлгийн мэргэжилтэн байгаа нь нийт эмч, мэргэжилтний 29.5 хувь болж өмнөх оноос 2 хувиар, суурь үзүүлэлтээс 7.4 хувиар тус тус нэмэгдсэн байна. Үр дүн: Мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо өмнөх оноос 2 хувиар, суур түвшинтэй харьцуулахад 7.4 хувиар өссөн байна.	100
6	Өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх, магистр, докторт суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Боловсролын зэрэгтэй эмчийн хувь	11.1%	13%	13.3%	Тайлант хугацаанд 8 сувилагч сувилахуйн шаталсан бакалавр, 5 мэргэжилтэн магистрын зэрэг хамгаалсан бөгөөд 6 эмч, эмнэлгийн мэргэжилтэн магистрын зэрэг хамгаалахаар, “Монгол улсын хеликобактерийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт бүтээлээр “Их сүүмэн” клиникийн эрхлэгч Анагаах ухааны докторын зэрэг хамгаалахаар суралцаж байна. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарт нийт 1695 боловсролын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байгаагаас 268 магистр, 5 доктор байна. Үр дүн: Эмч, мэргэжилтнүүдээс боловсролын магистрын зэрэгтэй эмчийн эзлэх хувь 13.3 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар, суурь түвшнээс 2.2 хувиар өссөн байна.	100
7	Гадаад улсад бэлтгэгдсэн эмч, мэргэжилтэн өөрийн мэдлэг, туршлагаа түгээн дэлгэрүүлэхийг дэмжих	Мэдлэг, туршлагаа дэлгэрүүлсэн эмч, мэргэжилтний тоо	-	1	53	2021-2024 онд гадаадын өндөр хөгжилтэй оронд 122 эмч, эмнэлгийн мэргэжилтэн туршлага судлан, сургалтад хамрагдаж мэдлэг чадвараа нэмэгдүүлсэн. Тухайлбал: 2022 онд Австри улсад зохион байгуулагдсан олон улсын мэдрэлийн эмч нарын сургалтад 1 эмч, АНУ-д зохион байгуулагдсан клиник эмгэг судлаачдын холбооны лаборатори оношилгооны сургалтад 1 эмч, Солонгос улсад зохион байгуулагдсан олон улсын дотрын эмч нарын сургалтад 1 эмч Япон улсад төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 3 сувилагчийг нийт 6 эмч, мэргэжилтнийг хамруулсан. - 2023 онд гадаадын өндөр хөгжилтэй 11 оронд ангиографи, нүүр ам судлал, бөөр судлал, хавдрын мэс засал, сувилахуй зэрэг чиглэлээр нийт 60 мэргэжилтэн туршлага судалж мэдлэг чадвараа нэмэгдүүлсэн. Ангиографи судсан дотуурх эмчилгээ оношилгоо судлалаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс 1 эмч, 1 техникчийг БНСУ-ын Халлям их сургуулийн Кангнам эмнэлэгт ангиографийн чиглэлээр мэргэжил дээшлүүлснээр ангиографийн оношилгоо эмчилгээг Орхон аймагт нутагшуулж хойд бүсийн хэмжээнд энэхүү оношилгоо эмчилгээг нийт 224 хүнд хийсэн үр дүнтэй байна.	100

						<p>- 2024 онд Эмч мэргэжилтнүүдийг сургаж хөгжүүлэх чиглэлээр БНСУ–ын Дэгү хоттой хамтран ажиллах гэрээ, Бусан хоттой хамтран ажиллах санамж бичгийг тус тус байгуулан телемедицин буюу алсын зайн оношилгоо нэвтрүүлэн нийт 14 үйлчлүүлэгчийн оношийг тодруулж эмчилгээнд хамруулсан. Хувийн хэвшлийн клиникийн 1 их эмч “Чихрийн шижин өвчний мутац”-ийн судалгаа хийж, судалгааны үр дүнгээр БНСУ-ын дотоод шүүрлийн эмч нарын олон улсын хуралд илтгэл тавьж оролцсон. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Дүрс оношилгооны тасгийн дурангийн 2 эмч БНСУ-ын дурангийн нийгэмлэгийн GO-IMKASID хөтөлбөрт хамрагдан Католик их сургуулийн дурангийн тасаг болон Сөүл хотын Кюн-Хэ их сургуулийн эмнэлгийн дурангийн тасагт дадлага хийж, хоол боловсруулах доод замын өвчнүүдийн оношилгоо, эмчилгээний талаар олон улсын хуралд оролцсоноор ходоодны хавдрын эрт үед дурангийн аргаар салст хуулах хагалгааг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд нутагшуулсан байна. Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дүрс оношилгооны 1 эмчийг ОХУ-ын Маиовшин сургуульд хөхний MRI шинжилгээ чиглэлээр суралцуулж мэргэшүүлснээр 580 үйлчлүүлэгчид хөхний MRI шинжилгээ хийсэн байна.</p> <p>Үр дүн: Гадаадын өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлсэн эмнэлгийн мэргэжилтэн өмнөх онтой харьцуулахад 8.0 хувиар өссөн.</p>	
8	Эмч, эмнэлгийн мэргэжилтний гадаад хэлний мэдлэгийн түвшнийг үе шаттайгаар дээшлүүлэх, суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Гадаад хэлний мэдлэгийн түвшин, дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	18.4%	20%	27.3%	<p>Эмнэлгийн залуу мэргэжилтний англи хэлний чадварыг дээшлүүлэх зорилгоор англи хэлний анхан шатны сургалтад 14, англи хэлний дунд шатны сургалтад 30 эрүүл мэндийн ажилтныг хамруулсан. UpToDate программын хэрэглээг өргөжүүлэх болон анагаахын англи хэлийг сайжруулах сургалтад эрүүл мэндийн салбарын 80 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Аймгийн хэмжээнд гадаад хэлний мэдлэгийн түвшин, дээшлүүлсэн нийт 326 эмч, эмнэлгийн мэргэжилтэн байна.</p> <p>Үр дүн: Гадаад хэлний мэдлэгийн түвшин, дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 27.3 хувь болж суурь түвшинтэй харьцуулахад 8.9 хувиар нэмэгдсэн байна.</p>	100
9	Эмнэлгийн практик шинэ төрлийн эмчилгээ нэвтрүүлэх	Эмнэлгийн практикт нэвтрүүлсэн шинэ төрлийн эмчилгээ үйлчилгээний тоо	5	4	8	<p>2021 онд 15 нэр төрлийн өндөр өртөг бүхий техник тоног төхөөрөмж, 21 нэр төрлийн тусламж үйлчилгээ, 2022 онд 35 нэр төрлийн өндөр өртөг бүхий техник тоног төхөөрөмж, 17 нэр төрлийн тусламж үйлчилгээ, 2023 онд 12 нэр төрлийн өндөр өртөг бүхий техник тоног төхөөрөмж, тусламж үйлчилгээ, 2024 онд 8 төрлийн өндөр өртөг бүхий техник тоног төхөөрөмж, тусламж үйлчилгээг нэвтрүүлж, тоног төхөөрөмжийн хангалт дунджаар 90.8%, ашиглалт 90.6% байна. Тухайлбал:</p>	100

					<ul style="list-style-type: none"> <li>- Бүсийн оношилгоо эмчилгээний төвд Эрүүл мэндийн дэмжих төвд улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 34 нэр тоног төхөөрөмж, Хөнгөвчлөх, уламжлалтын тасагт орон нутгийн хөрөнгө оруулалтаар 140 сая төгрөгийн 17 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангагдан тусламж үйлчилгээг үзүүлж байна. Харвалт шигдээсийн төвд судсан дотуурх оношилгоо, хүүхдийн ясны хагалгааны шинэ төрөл, ходоод тайрах хагалгааг нутагшуулсан. Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр нээгдсэн Эрэгтэйчүүдийн кабинетад дурангаар шээлгүүрт стент тавих, чулуу авах 2 үе шаттай хагалгааг хийж байна.</li> <li>- Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт өндөр хүчин чадал бүхий 1.5 тесла Signa creator MRI аппарат болон компьютер томографийн аппаратыг шинээр суурилуулан эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөөр дүрс оношилгоог тайлант хугацаанд 258 хүнд хийсэн.</li> <li>- Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэгт хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг оношилгооны "CerviCage AI" системийг нэвтрүүлэн 1007 хүнд үзлэг, шинжилгээ хийж, үтрээний шүүрлийн шинжилгээг 927 хүнд, RMC эмнэлэгтэй хамтарсан үргүйдлийн оношилгооны кабинетаар 26 хүнд оношилгоо хийсэн.</li> <li>- Эрхэст Оргил клиникт хамрын дайвар, таславч нөхөх, хэнгэрэг нөхөх хагалгаа, сонсгол бууралтын түвшин тогтоож, дэвшилтэт технологийн хиймэл оюун ухаан бүхий сонсголын аппаратыг нэвтрүүлсэн.</li> <li>- "Мажаа" клиник нь Diers 4D форматрик аппаратаар 268 хүний нугалмын гулсалт, эргэлт, суулт, муруйлтын зургийг богино хугацаанд өндөр нарийвчлалтайгаар авч байна.</li> <li>- "Нейрон" ор бүхий клиникт 24 цагийн нойрны бичлэг, уналт таталтыг тогтоох бичлэгийг бүс нутгийн хэмжээнд үзүүлж байна.</li> <li>- НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилтээр АШУҮИС-ийн "Нярайн скринингийн салбар төв"-ийг БОЭТ-ийн Нярайн тасагт байгуулсан, төрсөн нярай бүрт 5 төрлийн бодисын солилцооны эмгэг илрүүлэх нярайн скрининг оношилгоо хийгдэж байна.</li> <li>- НҮБ-ын Хүүхдийн Сан, аймгийн ЗДТГ-тай хамтран хэрэгжүүлж байгаа стрептококкын скрининг үзлэгт 5400 гаруй хүүхдийг хамруулсан.</li> <li>- Орбис олон улсын байгууллагын санхүүжилтээр ЭХЭМҮТ-тэй хамтран "Хүүхдийн нүдний хавдрыг илрүүлэх улаан рефлексийн арга"-ыг нэвтрүүлэн хүүхэд, нярайн 9 эмчийг сургалтад хамруулж, нүдний угийн улаан рефлексийг илрүүлэх багажаар 100% хангасан ба нүдний угийн улаан рефлексийн оношилгоог 305 нярайд хийхэд эмгэг илрээгүй байна.</li> </ul>	
--	--	--	--	--	--	--

						<p>Үр дүн: Тайлант хугацаанд эмнэлгийн тусламж үйлчилгээнд 58 шинэ төрлийн эмчилгээ, үйлчилгээг нэвтрүүлсэн байна.</p>	
10	Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглах, хэрэглэх аргад суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлэх	Суралцсан эрүүл мэндийн ажилтны тоо	3	3	5	<p>Шинэ дэвшилтэт технологийг ашиглах чиглэлээр 2021 онд 10 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 2022 онд 2 эмч, 2023 онд 2 эмч, 2024 онд 5 эмч, суралцсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2021 онд үе бүтээх солих мэс засал, эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, элэг цөс, нойр булчирхайн хавдрын мэс засал, хүүхдийн зүрх судас, компьютер томограф, рентген туяаны техникч, серологи судлалаар 7 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үндсэн мэргэшлийн 2 жилийн хугацаатай сургалтад гэмтэл согог судлалаар 2 эмч, дүрс оношилгоо судлалаар 1 их эмч суралцсан.</li> <li>- 2022 онд Компьютертомограф соронзон давтамж бүхий дүрс оношилгоо судлал, ангиограф судсан дотуурх эмчилгээ оношилгоо судлалаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс 1 эмч, тархины судасны бичлэг судлалаар 1 эмч суралцсан.</li> <li>- 2024 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Дүрс оношилгооны тасгийн дурангийн 2 эмч БНСУ-ын дурангийн нийгэмлэгийн GO-IMKASID хөтөлбөрт хамрагдан бүдүүн гэдэсний ургацаг авах, ходоод, бүдүүн гэдэсний хавдар хуулах, бүдүүн гэдэсний үрэвсэлт өвчнүүдийн оношилгооны болон эмчилгээний чиглэлээр мэдлэг ур чадвараа ахиулсан бөгөөд ходоодны хавдрын эрт үед дурангийн аргаар салст хуулах хагалгааг нэвтрүүлэн 76 хүнд хагалгаа хийгдэж, лавлагаа шатлалд явах урсгалыг 10%-иар бууруулсан байна.</li> <li>- Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дүрс оношилгооны 1 эмчийг ОХУ-ын Маиовшин сургуульд хөхний MRI шинжилгээ чиглэлээр суралцахад нь хариуцлагын гэрээ хийж сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд суралцаж ирснээр 580 үйлчлүүлэгчид хөхний MRI шинжилгээ хийсэн.</li> <li>- Доод мөчдийн өнгөц венийн судасны мэс засал чиглэлээр 2 эмчийг нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, тус бүр 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн сургаснаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэс заслын тасагт тус дэвшилтэт технологийг Шастиний нэрэмжит 3-р эмнэлгийн баг эмч нартай хамтран нэвтрүүлж, нутагшуулахаар төлөвлөн бэлтгэл ажил хангагдсан.</li> </ul> <p>Үр дүн: Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлсэн эрүүл мэндийн ажилтны тоо өмнөх онтой харьцуулахад 60%, суурь түвшинтэй харьцуулахад 40%-иар нэмэгдсэн байна.</p>	100
11	Эрүүл мэндийн байгууллагууд цахим тоног төхөөрөмж	Цахим тоног төхөөрөмжөөр	2	1	11	<p>Тайлант хугацаанд телемедициний хэрэглээг нэмэгдүүлэн нийт 57 өвчтөний мэдээллийг телемедицинээр дамжуулан оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авсан байна.</p>	100

	ашиглан суралцах, эмчилгээ оношилгоонд ашиглах боломж бүрдүүлэх	хангагдсан байгууллагын тоо				<ul style="list-style-type: none"> <li>- БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төв Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2023 онд байгуулагдсан бөгөөд тус хугацаанд нийт 21 өвчтөнд зөвлөгөө авсан байна.</li> <li>- БОЭТ-ийн Төрөх тасгийн телемедициний төхөөрөмжөөр ЭХЭМҮТөөөөс 3 өвчтөний, зүрх судасны өвчний оношилгоо, эмчилгээний чиглэлээр зөвлөгөө авах шаардлагатай 32 өвчтөний мэдээллийг алсын зайн сүлжээгээр дамжуулж оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан. Зүрх судасны үндэсний mn.Cardio программын цахим өвчний түүхэнд 215 хүний мэдээллийг оруулсан байна.</li> <li>- Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй 2 удаа холбогдож уушги, зүрх судасны өвчний эмгэгийн оношилгоо, эмчилгээний чиглэлээр оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан.</li> <li>- “Цахим Эрдэнэт-1” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг 20 ширхэг планетаар хангаснаар түргэн тусламжийн дуудлага болон өрхийн гэрийн эргэлтээр тусламж үйлчилгээ үзүүлсэн эмч тухайн иргэний өвчний түүхийн мэдээллийг цахим системээс харах, үзлэгийн бүртгэл шивэлт хийх, хөнгөлөлттэй эмийн жорыг тухай бүрт нь бичиж хүлээгдэл, чирэгдлийг бууруулж, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерын хангалт 95 хувьд хүрсэн.</li> <li>- Жаргалант сумын эрүүл мэндийн төвд эмнэлзүйн хүнд өвчтөнд авах арга хэмжээний зөвлөмжийг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн, мэргэшсэн эмч нараас телемедицинээр авах нөхцөл бололцоо бүрдсэн.</li> <li>- Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон 5 өрхийн эрүүл мэндийн төвд Мобайл технологи хэрэгжиж тайлант хугацаанд мобайл технологиор гэрийн эргэлтийн IV, V-р бүлгийн эргэлт, алслагдсан багийн малчдын эргэлт, явуулын үзлэг, байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэг зэрэгт ашиглаж давхардсан тоогоор 10000 гаруй хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.</li> </ul> <p>Үр дүн: Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмж бүхий байгууллагын тоо 11 болж өмнөх оноос 1-ээр, суурь түвшинтэй харьцуулахад 9-өөр нэмэгдсэн.</p>	
12	Гадаад, дотоодын эмч нартай ажил мэргэжлийн туршлага солилцох, ажлын байр сэлгэн ажиллах нөхцөлийг бий болгох	Сэлгэн ажилласан эмчийн тоо	-	3	135	<p>2021 онд 21, 2022 онд 171, 2023 онд 108, 2024 онд 135 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад сэлгэн ажиллуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Коронавируст халдварын цар тахлын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн</li> </ul>	100

					<p>мэргэжилтнээс бүрдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй баг 1 сарын хугацаатай Халдварт өвчин судлалын үндэсний төвд сэлгэн ажилласан. Мөн хувийн хэвшлийн үндсэн тусламж үйлчилгээний 5 их эмч, клиникийн 3 их эмч, 4 эм зүйч тусгаарлах эмнэлэг болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн угтах үйлчилгээ, бүртгэл мэдээллийн ажилтнаар сэлгэн ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хувийн хэвшлийн 2 тусгаарлах эмнэлэгт Улаанбаатар хотоос уушгины эмч болон 2 дотрын эмч ирж ажилласан.</li> <li>- Мөнхийн үйлс эмнэлэгт уламжлалтын эмч 1 жилийн хугацаатай гэрээгээр ажилласан.</li> <li>- Их тавт эмнэлэгт чанарын алба, хоол үйлдвэрлэлд гэрээгээр зөвлөх эмч нарыг сэлгэн ажиллуулсан.</li> <li>- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хүүхдийн тасагт томуу томуу төст өвчний дэгдэлттэй холбоотой сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн эмнэлгийн давхардсан тоогоор нийт 263 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажиллуулсан байна.</li> <li>- Хувийн хэвшлийн ор бүхий 10 клиник нь 8 эмч зүйчийг гэрээгээр ажиллуулж байна.</li> <li>- Уламжлалт анагаах ухааны хувийн хэвшлийн эмнэлгийн 9 эмчийг Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон Эрдэнэт сувиллын цогцолборын сэргээн засах тасагт сэлгэн ажиллуулан чадавхжуулсан.</li> </ul> <p>Үр дүн: Ажил мэргэжлийн туршлага солилцон, ажлын байр сэлгэн ажилласан эмчийн тоо өмнөх онтой харьцуулахад 25%-иар, 2021 онтой харьцуулахад 6.4 дахин нэмэгдсэн байна.</p>		
13	Анагаах ухааны төрөлжсөн номын сан байгуулах	Номын сангийн тоо	2	-	2	<p>Эрүүл мэндийн газрын Анагаах ухааны төрөлжсөн номын санд Англи, Орос, Монгол хэлний 1000 орчим номын баяжилт хийж, “Цахим номын сан” үүлэн технологид суурилсан номын сангийн автоматжуулалтын олон улсын программ “МОНКОХА” программыг нэвтрүүлсэн</p> <p>Тайлант хугацаанд Баян-Өндөр мед” нэгдсэн эмнэлэг, “Үйлс бадрах” “Нийцэл” өрхийн эрүүл мэндийн төв нь анагаах ухааны төрөлжсөн номын сан шинээр байгуулж, номын сан хариуцсан ажилтныг томилж ажиллуулснаар тухайн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн сурч хөгжих боломжоор хангагдсан. Аймгийн хэмжээнд нийт 5 эрүүл мэндийн байгууллагад номын сан ажиллаж байна.</p> <p>Үр дүн: Анагаах ухааны төрөлжсөн номын сангийн тоо 5 болж суурь түвшинтэй харьцуулахад 3-аар нэмэгдсэн.</p>	100
14	Нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөлдөх	Уулзалт, зөвлөгөөний тоо, үр дүн	1	1	1	<p>Тайлант хугацаанд 5 удаагийн хэлэлцүүлэг, 2 зөвлөгөөн, 2 чуулган, 1 хурал, 5 зөвлөлдөх уулзалтад нийт 1055 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаад байна. Үүнд:</p>	100



	уулзалтыг жил бүр зохион байгуулах				<ul style="list-style-type: none"> <li>- Ковид-19-ын цар тахлын үед ЭМГ-ын дэргэд эмнэлзүйн баг, нарийн мэргэжлийн зөвлөгөө өгөх эмч нарын багийг томилон 4 удаагийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 250 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтэнд эмнэлзүйн чиглэлээр сургалт зохион байгуулсан. Эмнэлзүйн баг, эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудыг оролцуулсан 1 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.</li> <li>- ДЭМБ, ЭМЯ, ЭЭХХЗГ хамтран зохион байгуулж буй “Орон нутаг дахь эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамж, хүртээмж, удирдлага зохион байгуулалт, чанар аюулгүй байдал” сэдэвт бүсчилсэн хэлэлцүүлэгт 100 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.</li> <li>- Анагаахын Шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Багш шавийн уулзалт”-ыг зохион байгуулж, 110 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.</li> <li>- Монгол Улсын Мэдээгүйжүүлэгч эмч нарын “Хагалгаа тойрны анагаах ухаан” сэдэвт зөвлөгөөн Орхон аймагт зохион байгуулагдаж, 105 эмч мэргэжилтэн оролцсон.</li> <li>- “Сувилахуй ба эрх зүй” сургалт, хэлэлцүүлгийг УИХ-ын гишүүн Д.Батлут, Ж.Чинбүрэн нарын ажлын албатай хамтран зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 12.5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж, төвийн бүсийн 6 аймгийн 300 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг оролцуулсан.</li> <li>- Монголын гэмтэл согогийн эмч мэргэжилтнүүдийн холбоо, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Орхон аймгийн “Бүсийн оношлогоо эмчилгээний төв”-тэй хамтран гэмтэл согог судлалын XXV олон улсын эрдмийн чуулганыг “Эрүүл иргэн-Эрсдэлгүй үйлчилгээ” уриан дор зохион байгуулж, ОХУ, Энэтхэг, ХБНГУ-ын эрдэмтэн, судлаачдаас гадна Улаанбаатар хот, орон нутгийн нийт 160 гаруй гэмтэл согог судлалын эмч, мэргэжилтэн оролцуулсан.</li> <li>- Удирдах ажилтны зөвлөгөөнийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулъя” уриан дор зохион байгуулж салбарын 150 удирдах ажилтан оролцсон.</li> <li>- Эмнэлзүйн ховор тохиолдлын хэлэлцүүлгийг тубероз склероз өвчин, саггитал венийн синусын тромбоз өвчний чиглэлээр 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 70 эмчийг хамруулсан.</li> <li>- Монголын гэмтэл согогийн эмч мэргэжилтнүүдийн холбоо, АШУҮИС-ийн АУС-ийн Гэмтэл согог судлалын тэнхим, Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс хамтран зохион байгуулсан Гэмтэл согог судлалын XXVI эрдмийн чуулганд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн гэмтлийн тасгийн 1 их эмч, томуугийн үндэсний зөвлөлдөх</li> </ul>	
--	------------------------------------	--	--	--	--	--

						уулзалтад 3 эмч, мэргэжилтэн, Их эмч нарын 7-р их хуралд 15 их эмч, бага эмч нарын анхдугаар зөвлөгөөнд 5 бага эмч оролцож хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эмчилгээ, оношилгоо, үйлчилгээний шилдэг арга барил, туршлагыг солилцсон байна. Үр дүн: Тайлант хугацаанд нийт 5 зөвлөлдөх уулзалт, нарийн мэргэжлийн эмч нарын 2 чуулган зохион байгуулагдсан байна.	
15	Эрүүл мэндийн ажилтны ёс зүйг хувь хүний хандлагад тулгуурлан төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулах	Ёс зүйн зөрчил гараагүй байх	-	-	-	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн ажилтны ёс зүйг хувь хүний хандлагад тулгуурлан төлөвшүүлэх 158 удаагийн сургалтад нийт 6705 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан байна. Тухайлбал: 2021 онд 34 удаагийн сургалтад 1191, 2022 онд 38 удаагийн сургалтад давхардсан тоогоор 2224, 2023 онд 47 удаагийн сургалтад 2257, 2024 онд 39 удаагийн соён гэгээрүүлэх сургалтад 1033 эмч, мэргэжилтэн тус тус хамрагдсан байна. ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос “Эмнэлгийн эрх зүй ба ёс зүй”, “Гамшгийн үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” сэдэвт багц цагийн сургалтуудад 345 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан “Хүний эрхэд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” 5 өдрийн сургалтад 145 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Соёлыг түгээе” аянд эрүүл мэндийн салбар байгууллагуудын хамт оролцож, “баярлалаа” “талархлаа” цахим давлагааг өрнүүлснээр 630 талархал ирсэн байна. Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан “Эмчийн гангараа” ярилцлага уулзалтад 30 ахмад эмч нарыг хамруулсан. Мөн эмч эмнэлгийн мэргэжилтний дунд “Яруу эгшиглэн-2023” шүлгийн уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж ирүүлсэн шүлгүүдээр “Нигүүлсэлийн цагаан өд” шүлгийн эмхэтгэл гарган түгээсэн. Тус хороонд эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлагатай холбоотой 2 өргөдөл ирснийг судлан шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд талархал нэмэгдэж, эрүүл мэндийн салбарын хэмжээнд үндсэн тусламж үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамж 95% болж өссөн. Үр дүн: Тайлант хугацаанд эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлагатай холбоотой 2 өргөдөл ирснийг судлан шийдвэрлэсэн.	90
16	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, байгууллагын хөгжил удирдлага төлөвлөлт зохион байгуулалтыг	Сэтгэл ханамжийн судалгааны дүн	80%	85%-аас дээш	89.5%	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн байгууллагуудын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд нийт 1244 үйлчлүүлэгч хамрагдсан байна. Судалгаагаар үйлчлүүлэгчдийн 89,5 хувь эрүүл мэндийн үйлчилгээнд сэтгэл ханамжтай үнэлгээг өгсөн байна. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг sudalгаа.1313.mn цахим системээр Бүсийн оношилгоо,	100

	сайжруулах зорилгоор үйлчлүүлэгчид, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг авах, судалгааны дүнг үндэслэн арга хэмжээг зохион байгуулах					эмчилгээний төвийн 27 тасаг, сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв QR код үүсгэн, байршуулж, үйлчлүүлэгч иргэдийг сэтгэл ханамжийн судалгаанд хамруулсан. Тайлант хугацаанд Орхон аймгийн 1410 иргэн тус судалгаанд оролцсоноос хэвтэн эмчлүүлсэн 12 иргэний 58.0 хувь нь эмнэлгийн тусламж үйлчилгээ маш сайн, 42.0 хувь нь сайн, амбулаториор үйлчлүүлсэн 1398 иргэний 55 хувь нь эмнэлгийн тусламж үйлчилгээ маш сайн гэж үнэлсэн ба өнгөрсөн оны мөн үеэс иргэдийн сэтгэл ханамж 8.5%-иар нэмэгдсэн байна. <i>Үр дүн:</i> Тайлант хугацаанд үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгаагаар үйлчлүүлэгчдийн 89.5 хувь нь сэтгэл ханамж өндөр гарсан нь суурь үзүүлэлттэй харьцуулахад 9.5%-иар нэмэгдсэн байна.	
17	Эрүүл мэндийн байгууллагуудын менежментийг сайжруулах, манлайллыг хөгжүүлэх чиглэлээр сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	Сургалтад хамрагдсан байгууллагын тоо	2	4	5	<p>Эрүүл мэндийн байгууллагуудын менежментийг сайжруулах, манлайллыг хөгжүүлэх ажлын хүрээнд тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн газар нь салбараасаа анхдагч Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж, уг стандартыг 3 өрхийн эрүүл мэндийн төв, 2 хувийн хэвшлийн ортой клиник нэвтрүүлж, гэрчилгээ гардан авсан байна. Тус хугацаанд 65 дотоод аудитуудыг бэлтгэсэн.</li> <li>- Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих стандарт MNS 7014:2023, Эрсдэлийн менежментийн тогтолцоо ISO 31000:2020-ны 5 удаагийн сургалтад 270 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бүсийн форумд 12 удирдах ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.</li> <li>- Эрүүл мэндийн салбарын хэмжээнд Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх сайн дурын НICO клубыг шинээр нээж 2 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.</li> <li>- “Монголын дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын хөгжил холбоо” төрийн бус байгууллагатай хамтран дотоод хяналтын болон эрсдэлийг удирдах арга зүйн 2 удаагийн сургалтад 100 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан гэрчилгээ олгосон.</li> <li>- Эрүүл мэндийн байгууллагын хагас бие даасан засаглал, гүйцэтгэлээр санхүүжих чиглэлээр сургалтад <u>эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага болон холбогдох эмч мэргэжилтэн 51 хүн хамрагдсан.</u></li> <li>- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, ДЭМБ-тай хамтран эмнэлгүүдийн хагас бие даасан засаглалыг хөгжүүлэх чиглэлээр хийгдсэн 2 удаагийн сургалтад Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн удирдлагын баг, тасгийн эрхлэгч нарыг бүрэн хамруулсан.</li> <li>- Эмэгтэйчүүдийн манлайлал багц цагийн сургалтад 4 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.</li> </ul>	100

						Үр дүн: Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудын менежментийг сайжруулах, манлайллыг хөгжүүлэх сургалтад 48 байгууллагын давхардсан тоогоор 10468 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан. Аймгийн хэмжээнд 5 эрүүл мэндийн байгууллага Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлсэн.	
Зорилт 2. Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлнэ.							
18	Эрүүл мэндийн ажилтнуудыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажилтны хувь, эмчлэн эрүүлжүүлсэн ажлын үр дүн	85%	80%-аас дээш	94%	<p>2021 онд эрүүл мэндийн салбарын ажилтны 91%, 2022 онд 92%, 2023 онд 93%, 2024 онд 94%-ийг тус тус урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үзлэгээр эмчлэн эрүүлжүүлэх шаардлагатай 880 ажилтнаас 304 ажилтныг өдрийн эмчилгээнд, 203 ажилтныг эмийн эмчилгээнд хамруулж, мэс засалд орох шаардлагатай 4 ажилтанд “Эмч” хөтөлбөрөөс нийт 6.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</li> <li>- Мэргэжлээс шалтгаалах өвчний асуудал эрхэлсэн төв байгууллагад илгээж онош тодруулах шаардлагатай ажилтан байхгүй байна.</li> <li>- Эрүүл мэндийн ажилчдын эрүүл мэндийг дэмжин эмчилгээ шаардлагатай албан хаагчдад “Эмч” хөтөлбөрийн дэмжлэгийн сангаас 2021 онд 44.5 сая төгрөгийн, 2023 онд онош тодруулах, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад эмчлүүлэх шаардлагатай 15 ажилтанд 12.6 сая төгрөгийн, 2024 онд мэс засалд орох шаардлагатай 4 ажилтанд 6.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</li> <li>- “Эмч” хөтөлбөрөөс: <ul style="list-style-type: none"> <li>- 2022 онд 10.0 сая төгрөгийн санхүүжилтээр Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 40-өөс дээш насны 330 ажилтныг хавдрын маркерын шинжилгээнд хамруулснаас 3 ажилтан өөрчлөлттэй гарсныг лавлагаа шатлалын эмнэлэгт онош тодруулсан.</li> <li>- 2023 онд 16.0 сая төгрөгийн санхүүжилтээр эрүүл мэндийн байгууллагын 40-ээс дээш насны 400 ажилтныг бамбай булчирхайн дааврын шинжилгээнд хамруулж, өөрчлөлттэй гарсан 49 ажилтныг нарийн мэргэжлийн эмчийн хяналтад оруулж эмчилсэн.</li> <li>- 2024 онд 7.0 сая төгрөгийн санхүүжилтээр 30-аас дээш насны 70 ажилтныг ServiCare Ai оношилгоонд хамруулж, онош баталгаажуулах шаардлагатай 7 хүнийг нарийн шинжилгээнд хамруулсан. Мөн эрүүл мэндийн салбарын 45-аас дээш насны 24 албан хаагчийг бүдүүн гэдэсний дурангийн оношилгоонд хамруулснаас бүдүүн гэдэсний ургацаг илэрсэн 4 ажилтанд ургацаг авах ажилбар хийгдсэн байна.</li> </ul> </li> </ul>	100

						<p>- Wyse фитнесстэй хамтран эрүүл мэндийн салбар байгууллагуудын 60 албан хаагчийг 50 хувийн хөнгөлөлтэй үнээр жилийн турш дасгал хөдөлгөөн хийх гэрээ байгуулан хамруулж ажилласан.</p> <p>- Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс цацраг идэвхт тоног төхөөрөмжтэй харьцаж ажилладаг дүрс оношилгооны тасгийн 13 ажилтныг Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл мэндийн төвд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулахад жил бүр 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>Тайлант хугацаанд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтээр өөрчлөлттэй гарсан ажилчдын 96%-ийг эмчлэн эрүүлжүүлсэн бөгөөд 4% нь үргэлжлүүлэн эмчийн хяналтад эмчлүүлж байна. Тоог нягтлах Энэ цэнхэрээр бичсэн тоо хэрэггүй байхаа. Дээр улаанаар тайлбарыг бичсэн байна.</p> <p>Үр дүн: Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтны хувь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1%-аар, суурь түвшинтэй харьцуулахад 9%-аар нэмэгдсэн. Эмчлэн эрүүлжүүлсэн ажлын үр дүн 96% байна.</p>	
19	Эрүүл мэндийн салбарын ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх чийрэгжүүлэлт болон амрах өрөөг засаж, тохижуулах	Тохижуулсан танхимын тоо	5	1-ээр нэмэг дүүлэх	10	<p>Эрүүл мэндийн салбарын ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх зорилгоор чийрэгжүүлэлт болон амрах өрөөг салбарын хэмжээнд 2021 онд 17, 2022 онд 17, 2023 онд 12, 2024 онд 1-ийг засаж, тохижуулсан байна.</p> <p>“Эмч” хөтөлбөр хэрэгжсэнээс хойш өссөн дүнгээр 47 эрүүл мэндийн байгууллага засвар тохижилт хийж ажилчдын чийрэгжүүлэлт болон амрах өрөөг засаж, тохижуулсан байна.</p> <p>Үр дүн: Нийт эрүүл мэндийн байгууллагуудын 26.8 хувь нь засвар тохижилт хийж ажилчдын чийрэгжүүлэлт болон амрах өрөөг засаж, тохижуулсан байна.</p>	100
20	Гэр болон түрээсийн орон сууцанд хамруулах	Хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	12	3	15	<p>Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн халдвартын тасгийн ажилтны гэр гал түймэрт өртсөн тул 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</li> <li>- Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын 14 ажилтан 2023 онд түрээсийн орон сууцаар, 2024 онд 1 залуу эмчийн гэр бүлийг түрээсийн орон сууцаар хангасан.</li> <li>- Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 2022 онд олон жил ажиллаж байгаа 30 ажилтанд орон сууц худалдан авахад зориулан урьдчилгаа төлбөр тус бүр 20,0 сая төгрөг олгосноос 28 ажилтан нь орон сууцанд орсон байна.</li> <li>- Эрдэнэт сувиллын цогцолбор нь 2022 онд орон сууц худалдан авсан 6 ажилтанд нийт 78.0 сая төгрөг, 2023 онд орон сууц худалдан авсан 2 ажилтанд 26.0 сая төгрөг, 2024 онд орон сууц</li> </ul>	100

						<p>худалдан авсан 3 ажилтанд 39.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрдэнэт медиал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь 2022 онд 3 албан хаагчид орон сууцны урьдчилгааг олгох эрхийн бичгийг олгосон бөгөөд өнөөгийн байдлаар тус эмнэлгийн 50 албан хаагч байгууллагын түрээсийн орон сууцаар хангагдсан байна.</li> </ul> <p>Үр дүн: Тайлант хугацаанд 1 ажилтанд гэр, 44 ажилтанд орон сууцны дэмжлэг үзүүлж, түрээсийн орон сууцанд эрүүл мэндийн салбарын 15 ажилтан орсон байна.</p>	
21	Ахмад эмч, сувилагч нарыг мэргэжлийн сургалтад хамруулж цаг үеийн мэдээллээр ханган хамтран эрүүл мэндийн арга хэмжээ зохион байгуулах	Сургалт мэдээлэлд хамрагдсан хувь	-	25%	29.8%	<p>Ахмад эмч, сувилагч нарыг цаг үеийн мэдээллээр хангах, эмч, эмнэлгийн мэргэжилтний ажил мэргэжлийг сурталчлах арга хэмжээнд 357 ахмад эмч, сувилагч буюу ахмад эмч, сувилагч нарын 29.8 хувийг хамруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Коронавируст халдвар /ковид/-ын цар тахал, хариу арга хэмжээний сургалтад 11 ахмад хамрагдаж, цаг үеийн мэдээллээр хангагдан хамтран ажилласан.</li> <li>- Эрдэнэтийн өдрийг угтан “Ахмадаа хүндэтгэе-2023” арга хэмжээнд 35 ахмадыг хамруулж, аймгийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, хамтран ажиллах чиглэлээр санал солилцсон.</li> <li>- Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Эрүүл мэндийн байгууллагуудын ажиллагсдын Үйлдвэрчний эвлэлийн хороо хамтран “Эмчийн гангараа” уулзалт ярилцлагыг 30 ахмад эмч нарыг хамруулан зохион байгуулж, мэдээллээр ханган, үйл ажиллагааг сурталчилсан.</li> <li>- Эрүүл мэндийн байгууллагаас тэтгэвэрт гарсан “Буурлын чагнуур” төрийн бус байгууллагын 15 гишүүн сайн дурын ажилтнаар бэлтгэгдэн “Ач санах” хөтөлбөрийн 2.0 сая төгрөгийг санхүүжилтээр хэвтрийн хүнд өвчтэй 60 хүнийг гэрийн асаргаа сувилгаанд хамруулсан бөгөөд тус сайн дурын ажилтнуудыг цаг үеийн мэдээллээр тогтмол хангаж ажилласан.</li> <li>- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй 16 ахмад эмчийг халдвар хамгааллын чиглэлээр сургалтад хамруулсан.</li> <li>- Орхон аймгийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэхэд гар бие оролцон өндөр насны тэтгэвэрт гарсан анхдагч ахмадууд болон ажиллаж байгаа ахмадуудын түүх, дурсамжийг бүтээх, ахмадуудаасаа туршлага судлах уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж 150 ахмадыг хамруулсан.</li> <li>- Шинэ үеийн үйл ажиллагаанд уламжлалыг сайжруулж нэвтрүүлэх, ололт амжилтаас залуу үеэ сургаж, төлөвшүүлэх чиглэлээр Эрдэнэт хотын “Илгээлтийн эзэд” эрүүл мэндийн</li> </ul>	100

					салбарын 100 ахмадын хамруулсан уулзалтыг зохион байгуулсан. Үр дүн: Сургалт мэдээллийн арга хэмжээнд ахмад эмч, сувилагч нарын 29.8 хувийг хамруулж зорилтот түвшинд хүрсэн байна.		
22	Нийгмийн ноцтой байдлын үед ялангуяа коронавируст халдвар /ковид/-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх	Эмч эмнэлгийн ажилчдын дэмжлэгт хамрагдсан хувь	-	Гүйцэтгэл ээр	-	2021 онд цар тахлын голомтод ажиллаж буй эрүүл мэндийн ажилтныг дэмжиж Эрүүл мэндийн яамнаас 1348 эмч, эмнэлгийн ажилтанд нийт 969.4 сая төгрөгийн тэтгэмж, аймгийн Засаг даргын захирамжаар давхардсан тоогоор 460 эрүүл мэндийн ажилтанд 51.0 сая төгрөгийн урамшуулал, давхардсан тоогоор дайчлагдан ажилласан 250 эрүүл мэндийн ажилтанд илүү цагийн хөлс 161.4 сая төгрөгийг олгосон. 2022 онд Эрүүл мэндийн бүх ажилтнуудыг халдвараас сэргийлэх, тэдний дархлааг дэмжих зорилгоор хүрээнд томуугийн сайн дурын дархлаажуулалтад 115 эмч эмнэлгийн ажилчдыг хамруулж 512 ажилтанд витамин С /1000 мг/, витамин Д /2000ед/ нэг сарын хэрэглээгээр хангасан. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг 100% дархлааг дэмжих аминдэм, халуун хоол, халуун аарц, чацаргана, амны хаалт зэргээр хангасан. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үеэр аймгийн шуурхай штабт 2022 оны эхний улирлыг дуустал ажилласан 6 эмч, мэргэжилтэнд илүү цагийн хөлсийг бодож олгосон. 2023 онд аймгийн Засаг даргын 2023 оны А/937 дугаар захирамжаар томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед хариу арга хэмжээнд ажиллаж буй 87 эмчид нийт 20.0 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгогдсон. 2024 онд аймгийн Засаг даргын 2023 оны А/937 дугаар захирамжаар томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед хариу арга хэмжээнд ажиллаж буй 87 эмчид нийт 20.0 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгогдсон. Орхон аймгийн баяр наадмын нээлтийн арга хэмжээнд оролцогчдын дунд бүртгэгдсэн хоолны хордлогын халдварын дэгдэлтийн үед ажилласан ЭМГ-ын эрүүл ахуй халдвар хамгааллын улсын хяналтын байцаагч нар болон мэргэжилтнүүдийн илүү цагаар ажилласан хөлсийг давхардсан тоогоор 13 хүнд 6.4 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон. Үр дүн: Нийгмийн ноцтой байдлын үед ялангуяа коронавируст халдвар /ковид/-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажилласан эмч эмнэлгийн ажилчид 100% дэмжлэгт хамрагдсан. Нийгмийн ноцтой байдлын үед ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд илүү цагийн хөлсийг 100% бодож олгосон байна.	100
	Жил бүр аймгийн “Тэргүүний эрүүл мэндийн ажилтан”-ыг	Шалгарсан эрүүл мэндийн ажилтны тоо	-	1		Жил бүр аймгийн “Тэргүүний эрүүл мэндийн ажилтан”-ыг сонгон шалгаруулж урамшуулж ирсэн. - 2021 оны алдартнаар Мөнхсүндэрл өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Б.Жаргалсайхан,	100

23	сонгон шалгаруулж, урамшуулдаг байх					<ul style="list-style-type: none"> <li>- 2022 онд “Тэргүүний эрүүл мэндийн ажилтан”-аар “Мөнхсүндрэл” ӨЭМТ-ийн их эмч Г.Хишигжаргал,</li> <li>- 2023 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Гэмтлийн тасгийн их эмч Ч.Балдорж болон “Их тавт” ор бүхий клиникийн их эмч М.Энхтуяа,</li> <li>- 2024 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмгэг судлалын тасгийн Эрхлэгч Х.Нандинцэцэг нар тус тус шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.</li> </ul> <p>Үр дүн: Эмч нарын ажлыг бодитой дүгнэн, ажиллах урам, бүтээлч хандлагыг нэмэгдүүлсэн.</p>	
	<b>Нийт хэрэгжилтийн дундаж</b>						<b>98.6 %</b>



“ЭМЧ” ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ /2021-2024 он/

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2020 он/	2024 онд хүрэх түвшин	Хүрсэн түвшин 2021 он	Хүрсэн түвшин 2022 он	Хүрсэн түвшин 2023 он	Хүрсэн түвшин 2024 он	Тайлбар	Хэрэгжилт ийн хувь
<i>Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, төлөвшил, ёс зүй, хандлага, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:</i>									
1	Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	71.4	80	71.4	73	79	86	Аймгийн хэмжээнд төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний хувь 86%-д хүрч өмнөх оноос 7.0 хувиар, суурь түвшнээс 14.6 хувиар нэмэгдсэн.	100
2	Мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь /ахлах, тэргүүлэх/	22.1	26	22.1	23	27.6	29.5	Мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 29.5 хувь болж, өмнөх онтой харьцуулахад 1.9 хувиар, суурь түвшнээс 7.4 хувиар нэмэгдсэн.	100
3	Боловсролын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь /магистр, доктор/	11.1	13	11	11.1	13.2	13.3	Боловсролын магистр, докторын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь өмнөх онтой харьцуулахад 0.1 хувиар, суурь түвшнээс 2.2 хувиар нэмэгдсэн.	100
4	Гадаадад мэргэжил дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	22.7	25	22.7	23	31	39	Нийт 119 мэргэжилтэн гадаадын өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлсэн бөгөөд гадаадад мэргэжил дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь суурь түвшнээс 16.3 хувиар нэмэгдсэн.	100
5	Гадаад хэлний түвшин дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	18.4	20	18.4	19.6	20	27.3	Гадаад хэлний мэдлэгийн түвшин дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь өмнөх онтой харьцуулахад 5.2 хувиар, суурь түвшнээс 8.9 хувиар өссөн байна.	100

6	Судалгаа, шинжилгээний ажил хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	17.0	20.0	17.5	18	20	15.4	Тайлант хугацаанд судалгаа, шинжилгээний ажил хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь, 15.4 хувийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 3.6 хувиар буурсан байна.	77
7	Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн, өгүүлэл нийтлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	18	20	26	30	224	187	Гадаад, дотоодын Эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо суурь түвшнээс 10.4 дахин нэмэгдэж зорилтот түвшинд хүрсэн.	100
8	Шинэ төрлийн эмчилгээ, үйлчилгээ нэвтрүүлсэн тоо	5	12	3	17	32	8	Хөтөлбөр хэрэгжсэнээр өссөн дүнгээр лавлагаа шатлалд нийт 60 нэр төрлийн өндөр өртөг бүхий техник тоног төхөөрөмж, тусламж үйлчилгээг нэвтрүүлж, тоног төхөөрөмжийн хангалт дунджаар 90.8%, ашиглалт 90.6% байна.	100
9	Ёс зүйн сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	1699	2000	2191	2224	2257	2033	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо жил бүр нэмэгдэн, зорилтот түвшинд хүрсэн.	100
10	Иргэдээс ирсэн өргөдөл гомдлын эзлэх хувь	3.1	0	7.4	0	0	0.5	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой өргөдөл 2 өргөдөл ирснийг шалган шийдвэрлэсэн.	90
<i>Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангаж, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд</i>									
11	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эмч, эмнэлгийн ажиллагсдын эзлэх хувь	85	90	91	92	93	94	Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт эмч, эмнэлгийн ажиллагсдын 94% хамрагдаж, өмнөх онтой харьцуулахад 1 хувиар, суурь түвшнээс 9 хувиар нэмэгдсэн.	100
12	Эмчлэн эрүүлжүүлсэн эрүүл мэндийн ажилтны тоо	700	740	408	188	787	880	Урьдчилан сэргийлэх үзлэгээр өссөн дүнгээр шинжилгээ хийлгэх,	100

								эмчлүүлэх шаардлагатай нийт эрүүл мэндийн ажилтны 96 хувийг эмчлэн эрүүлжүүлсэн.	
13	Шинээр тохижуулсан амрах өрөө болон чийрэгжүүлэлтийн өрөө	14	20	10	12	46	47	Хөтөлбөр хэрэгжсэнээс хойш өссөн дүнгээр нийт 47 эрүүл мэндийн байгууллага буюу нийт эрүүл мэндийн байгууллагуудын 26.8 хувь нь засвар тохижилт хийж ажилчдын чийрэгжүүлэлт болон амрах өрөөг засаж, тохижуулсан байна.	100
14	Гэр болон түрээсийн орон сууцанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	12	12	14	30	30	51	Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын байгууллагуудын хэмжээнд түрээсийн орон сууцанд 51 эрүүл мэндийн ажилтан орж, 3 ажилтанд 13.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100
15	Нийгмийн ноцтой байдлын үед ялангуяа коронавируст халдвар /ковид/-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй Эмч, эмнэлгийн ажилчдын дэмжлэгт хамрагдсан хувь	-	40%	67%	100%	4.3	0.6%	- Цар тахлын голомтод ажиллаж буй эрүүл мэндийн ажилтны 2021 онд 67% нь, 2022 онд 100% дэмжлэгт хамрагдсан. 2023 онд томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед хариу арга хэмжээнд ажиллаж буй 87 эмчид эмчид нийт 20.0 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгогдсон. 2024 онд ЭМГ-ын эрүүл ахуй халдвар хамгааллын улсын хяналтын байцаагч болон мэргэжилтнүүд болох 13 хүнд 6.4 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг олгосон.	100
<b>Хэрэгжилтийн дундаж хувь</b>									<b>97.8%</b>

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР